



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/630

Булган сум

Цахим аймаг хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Харилцаа холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.5 дахь заалт, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/24 тоот тушаалаар батлагдсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл, Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цахим аймаг хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Цахим аймаг хөтөлбөр боловсруулахад шаардлагатай мэдээ мэдээллийг бэлтгэх ажлыг шуурхай хангаж, үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

3.Хөтөлбөр боловсруулалтын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, судалгаа, дүн шинжилгээ хийх, судалгааны дүнд үндэслэн боловсруулахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

4.Хөтөлбөр боловсруулах явц, үр дүнгийн талаарх мэдээллийг 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
09 дүгээр сарын 01-ны өдрийн А/620 дугаар
захирамжийн хавсралт



ЦАХИМ АЙМАГ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНД

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
- Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
- Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- Г.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
- Н.Булган (Булган аймаг дахь ТЦҮХ-ИЙН дарга)
- Б.Нямсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн)
- Ө.Өлзиймөрөн (Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн)
- Б.Буянжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн)
- Б. Ганболд (Татварын хэлтсийн мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн)
- Б.Отгонбат (Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээлэл технологи хариуцсан сүлжээний ажилтан)
- Б.Отгонбаяр (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга: Б.Энхмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн өргөдөл гомдол, мэдээллийн ил тод, цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)